



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 12 өдөр

Дугаар A/640

Номгон


Г Нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн “Ковид-19” цар тахлын үеийн эмчилгээ, үйлчилгээний үед мөрдөх журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “а”, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.1, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 2021 оны 99 дүгээр тушаал, Эрүүл мэндийн сайдын “Шинэ коронавируст халдварт “Ковид-19”-ын оношлогоо, эмчилгээний түр заавар шинэчлэн батлах тухай” 2021 оны A/549 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Ковид-19” цар тахлын үеийн эмчилгээ, үйлчилгээний үед мөрдөх журмыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг үйл ажиллагаанд мөрдөж, хэрэгжүүлэн үр дүнг тооцож ажиллахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал), Нэгдсэн эмнэлэг (А.Ганболд), Эрүүл мэндийн даатгалын хэлтэс (А.Цэрмаа), Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Энхбаяр)-д даалгасугай.



601210493

D:\2021\Zakhiramj-2021 он\Захирамж-2021 он.docx

Аймгийн Засаг даргын 2021 оны 90 сарын 12  
өдрийн 11:54:00 дугаар захирамжийн  
хавсралт

НЭГДСЭН ЭМНЭЛЭГ, ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТӨВҮҮДИЙН КОВИДЫН ЭМЧИЛГЭЭ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ҮЕД МӨРДӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл:

**Зорилго:**

1.1. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн “Ковид-19” цар тахлын үеийн тусlamж үйлчилгээний харилцан зохицуулалтыг хангах

**Зохицуулах харилцаа:**

1.2. “Ковид-19” илрүүлэх PCR болон тестээр эзрэг гарч өвчилсөн иргэн Өрхийн Эрүүл мэндийн төвөөс эмчилгээний багц аван эмчлүүлж байгаад биеийн байдал хүндрэх, зарим нэг шалтгааны улмаас Нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхэд анхан шатны өрхийн эмнэлэг санхүүжилтээ авч чадахгүй байгаа тохиолдлыг зохицуулахад энэхүү журмыг мөрдлөгө болгоно.

**Хоёр. Хамрах хүрээ, хууль тогтоомж:**

2.1. Энэхүү журам нь аймгийн Нэгдсэн эмнэлэг болон Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн “Ковид-19” цар тахлын үеийн тусlamж үйлчилгээнд хамаарна.

2.2. Коронавирусын халдвартын эмчилгээ, үйлчилгээний үед Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 2021 оны 99 дүгээр тушаал, Эрүүл мэндийн сайдын 2021 оны A/239 дүгээр тушаалаар батлагдсан “Коронавируст халдвартын батлагдсан тохиолдлын гэрийн тусгаарлалтад эмчлэгдэх өвчтөнд эмнэлгийн тусlamж үзүүлэх түр журам”, ЭМС-ын 2021 оны A/319 дүгээр тушаалаар батлагдсан “Коронавирусын халдвартын үеийн хариу арга хэмжээний зураглал батлах тухай”, ЭМС-ын 2021 оны A/549 дүгээр тушаалаар батлагдсан “Шинэ коронавируст халдварт “Ковид-19”-ын оношлогоо, эмчилгээний түр заавар шинэчлэн батлах тухай” зэрэг журмыг тус тус чанд мөрдөн ажиллана.

2.3. Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ үзүүлэх байгууллагууд нь дээрх заавар журмуудыг мөрдөхөөс гадна дор дурдсан зарчыг баримтлана.

Хүн амын эрүүл мэндийн бодит хэрэгцээ, шаардлагыг баримтлах;

“Ковид-19” цар тахлын эмчилгээ үйлчилгээний талаар Эрүүл мэндийн салбарт баримталж буй бодлого, шийдвэрийг мөрдөх;

Төрийн үйлчилгээний ил тод, шуурхай, нээлттэй байдлыг хангах;

**Гурав. Нэгдсэн эмнэлгийн чиг үүрэг, үйл ажиллагаа.**

3.1.Нэгдсэн эмнэлэг нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1.Ковид-19 цар тахлын үеийн эмчилгээ, үйлчилгээний стандарт, заавар, журмын хүрээнд эмч мэргэжилтнийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

3.1.2.Эмнэлгийн тусlamж үйлчилгээтэй холбоотой тулгамдаж буй асуудал, хүндрэл бэрхшээлийн талаар санал боловсруулж, Эрүүл мэндийн газарт уламжлах;

3.1.3.Зөвхөн Шуурхай хариу арга хэмжээний багаас хүлээлгэн өгсөн иргэдийг хэвтүүлж эмчлэх;

3.1.4.Өрхийн эмчийн хяналтанд хөнгөн эрэмбээр эмчилгээний багц аван эмчлүүлж байгаа эмчлүүлэгчийг Нэгдсэн эмнэлэгт давхардуулан авч эмчлэхгүй байх;

3.1.5.Өвчтөний ар гэр, эцэг эх, хүүхдийн асран хамгаалагч, сахиуруудад давхар истори нээхгүй байх;

3.1.6.Хөдөө сумдад хэвтэн эмчлүүлж байгаа иргэдийг эрэмбэлэн хүнд эрэмбэтэй үйлчлүүлэгчийг 2-р шатлалд шилжүүлж авч эмчлэх;

3.1.7.Халдвар авч эмнэлэгт хэвтсэн иргэдийг эмнэл зүйн шинж тэмдэг харгалзахгүй эмчилгээг хугацаа алдахгүй эхлэх;

3.1.8.Өрхийн эмчийн хяналтанд хөнгөн эрэмбээр эмчлэгдэж буй өвчтөн эмнэл зүйн шинж тэмдэгээр хүндэрсэн тохиолдолд тухайн эмчлүүлэгчийн уугаад үлдсэн эмийг тусад нь савлуулан авч, өрхийн эрүүл мэндийн төвийн эрх бүхий ажилтан, албан тушаалтанд хүлээлгэн өгөх;

3.1.9.Нэгдсэн эмнэлгийн Эмийн нягтлан бодогч, урд өдрийн истори нээсэн эмчлүүлэгчийн нэрсийг маргааш нь 09 цагт Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ахлах сувилагчид хүргүүлэх;

**Дөрөв. Өрхийн эрүүл мэндийн төвийн чиг үүрэг, үйл ажиллагаа.**

4.1. Өрхийн эрүүл мэндийн төв нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.1.1.Өвчин хүндрэх эрсдэлт хүчин зүйл байхгүй, эмнэл зүйн хөнгөн шинж тэмдэгтэй хүнийг гэрийн нөхцөлд тусгаарлан хяналтандaa авч эмчлэх;

4.1.2.Хяналтанд байгаа иргэдтэй өдөр бүр холбогдож, биеийн байдалд тогтмол хяналт тавьж ажиллах;

4.1.3.Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч хоёрдугаар шатлалын эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх шаардлагатай иргэдийг Эрүүл мэндийн штабын 70440006 дугаар утсанд мэдэгдэж, орны очерт оруулах;

4.1.4.Хүндрэл өгсөн иргэдэд дуудлагаар үйлчлэхдээ анхан шатны тусlamж үзүүлэн тухайн өдрийн Шуурхай хариу арга хэмжээний багт хүлээлгэн өгөх;

4.1.5.“Ковид-19” илрүүлэх шинжилгээнд зэрэг гарч, онош баталгаажсан хөнгөн эрэмбийн үйлчлүүлэгчид эмчилгээний багц олгоходоо 3-5 хоногоор олгох;

4.1.6.Хяналтанд байгаа өвчтөн Нэгдсэн эмнэлэгт хэвтсэн тохиолдолд эмчилгээний давхардал үүсэхээс сэргийлж, тухайн өдрийн 10 цагаас өмнө 89759988 дугаарт холбогдож, өрхөөс олгосон эмчилгээний багц Нэгдсэн эмнэлэгт хийгдэх эмчилгээтэй давхардаж байгаа эмийг суутгаж авах;

#### **Тав. Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн чиг үүрэг, үйл ажиллагаа.**

5.1. Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5.1.1. Сар бүрийн 05-ны дотор өмнөх сарын гүйцэтгэлийг гэрээ бүхий Эрүүл мэндийн байгууллагуудаас хүлээн авч хянан, санхүүжилтийг сардаа багтаан олгоно.

5.1.2. Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс хэвтүүлэн болон гэрээр үзүүлэх тусlamж үйлчилгээний гүйцэтгэлийг авахдаа хариу арга хэмжээний багийн гаргасан эрэмбэлэн ангилалтын протоколыг үндсэн баримт болгоно.

5.1.3. Үйл ажиллагаандaa Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны 06 сарын 07-ны өдөр баталсан Эрүүл мэндийн байгууллагуудаас Ковид-19 халдварын үед иргэн даатгууллагчид үзүүлсэн тусlamж үйлчилгээний гүйцэтгэлийг хянах түр зааврыг чанд мөрдөн ажиллана.

5.1.4. Сар бүр эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлсэн талаар судалгааг Эрүүл мэндийн байгууллагуудаас гаргуулж авна.

#### **Зургаа. Хариуцлага**

6.1. Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар журмын хүрээнд гаргасан Ковидын эмчилгээ, тусlamж үйлчилгээний үед орон нутагт мөрдөх энэхүү журмыг зөрчсөн Эрүүл мэндийн байгууллага, эрх бүхий албан тушаалтанд хууль тогтоомжинд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.